

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2021-2024 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ БИЕЛЭЛТ

Өлгий сум

2024 оны 12 дугаар сарын 18

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги арга зам	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого, төлөвлөлт						
Үндсэн чиг үүргийн нэр: Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох						
Зорилго. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын, уялдаа холбоог сайжруулах						
	Арга хэмжээ 1. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативын дагуу насны ангиллаар жилд 2 удаа сорил авч, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжоор хангана	Улсын төсөв 1 сая төгрөг	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт /насны ангиллаар/ сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоонд харьцуулж 100-аар үржүүлнэ, хувиар тооцно	Суурь үзүүлэлт 2020 онд 71,6 хувь	2021 онд 72 хувьд, 2022 онд 74.2 хувьд, 2023 онд 75.5 хувьд, 2024 онд 78.1 хувьд хүргэх	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалт, МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх хүрээнд “БИЕ БЯЛДРЫН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛ”-ын аяныг аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэгийн 11817 хүүхдүүдээс сорил авч Биеийн тамир, спортын улсын хорооны мэдээллийн нэгдсэн санд сорилтын шивэлт хийгдсэн болно. 2024 оны байдлаар сорилд нийт хүн амын 11,2% хамрагдсан. Сорилд хамрагдсан иргэд, хүүхдүүдийн А,В,С үнэлгээтэй хувь 5.6 хувьтай байна. 2024 оны календарчилсан төлөвлөгөөний дагуу нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээ 12 удаа, аймгийн аварга шалгаруулах болон ойн арга хэмжээг 46 удаа, нийт 58 удаа биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулагдсан. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хүн амын 11.2% хамрагдсан.

Зорилт 1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1 дэх заалтын төлөвлөлтийн уялдаа

Зорилт 1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1 дэх заалтын төлөвлөлтийн уялдаа	Арга хэмжээ 2. Биеийн тамир, спортын салбарын “Цахим нэгдсэн мэдээллийн санг” тогтмол хөтлөн баяжуулалт хийж мэдээллийн технологийн баазыг бүрдүүлнэ	Улсын төсөв 2.0 сая төгрөг	Мэдээллийн сангийн үйл ажиллагаа эхэлж, цахим мэдээллийн сан бүрдэж, үйлчилгээ цахимаар үзүүлдэг болсон байна.	2020 оноос эхлэн хэрэгжиж байна	2021-2024 онд Спортын цол, сорил, спортын тэмцээн, наадмын ажил, үйлчилгээг цахимаар үзүүлдэг болсон байна	Орчин цагийн Биеийн тамир спортын салбарын түүхт 100 жилийн ойн хүрээнд биеийн тамир, спортын салбарын “Цахим нэгдсэн мэдээллийн сан”-д байгууллагын үйл ажиллагааг тогтмол байршуулж баяжуулалт хийгдсэн. Албаны цахим мэдээллийн санд нэгдсэн баазтай болж хэрэгжилтийн 65 хувьд хүрсэн. Тогтмол цахим мэдээллийн санд үйл ажиллагаагаа сурталчилж Ард иргэд хүссэн үедээ хэрэгтэй мэдээ мэдээллээтогтмол авах боломжийг бий болгож, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.
	Арга хэмжээ 3. Биеийн тамир, спортын төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана	Улсын төсөв 29.0 сая төгрөг	Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын тоо		2021 онд 2 ажил 2022 онд 5 ажил 2023 онд 9 ажил 2024 онд15 ажил шилжүүлэнэ	2024 онд аймгийн аварга шалгаруулах шатар, даам, ширээний теннис, волейбол, сагсан бөмбөг, таеквондо, тогыз хумалах, сур харваа, шагайн харваа, жүдо, чөлөөт бөх, үндэсний бөх, хөл бөмбөг зэрэг спортын төрлүүдийн өсвөр үе насанд хүрэгчдийн тэмцээнүүдийг тухайн спортын холбоод зохион байгуулж явуулсан. Дээрх 13 төрлийн тэмцээнийг спортын холбоодод шилжүүлэн гүйцэтгүүлсэн. Мөн "Астана-2024" Дэлхийн нүүдэлчдийн V наадам Казахстан улсын нийслэл Астана хотод есдүгээр сарын 8-13-ны өдрүүдэд болж, 89 орны 2700 орчим тамирчин спортын 21 төрөлд 97 багц медалийн төлөө өрсөлдлөө. Манай улсаас 115 тамирчин, дасгалжуулагч шүүгч албаны хүмүүсийн бүрэлдэхүүнтэй спортын 16 төрөлд 66 тамирчин өрсөлдөж, таван мөнгө, арван хүрэл медаль хүртсэн амжилт гаргалаа. Тус наадамд улсаа төлөөлөн аймгийн Биеийн тамир, спортын газар, Монголын Көкпар, Аударыспак, Тенге илухолбоо хамтран өргөн бүрэлдэхүүнтэй баг тамирчид, дасгалжуулагчид, шүүгч нар улсаа төлөөлөн оролцож, бахтам амжилт гаргаж эх орныхоо алтан соёмбот далбааг Казахстан Улсын тэнгэрт мангуйллаа
	Арга хэмжээ 4. Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлнэ	Улсын төсөв 130.0 сая төгрөг	Сумын биеийн тамирын арга зүйчийн тоог 13 хүргэх	2021 онд биеийн тамирын арга зүйчээр 2 хүн ажиллаж байна	2022 онд 2 хүн, 2023 онд 4 хүн 2024 онд 7 хүнээр нэмэгдүүлнэ	2024 оны байдлаар Биеийн тамир, спортын газард 4 арга зүйч, сумдад орон тооны 3 арга зүйч шинээр томилогдон тус тус ажиллаж байна.

	Арга хэмжээ 5. Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд төрийн болон хувийн өмчийн сургуулиудын спорт заалыг үнэгүй ашиглуулна	Орон нутгийн төсөв	Төлбөргүй үйлчилгээ үзүүлж буй спорт заалны тоо	Нийт 35 заалтай үүнээс төлбөргүй үйлчилгээ үзүүлж буй 2 заал байна.	2021 онд 4 заал 2022 онд 7 заал 2023 онд 12 заал 2024 онд 16 заал	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар "ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Илүүдэл Жингүй - Эртэч Монгол", "Цаг гаргая" аяныг дахин сэргээж аймгийн хэмжээнд иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, бие бялдраа чийрэгжүүлэх, биеийн дархлааг дэмжин биеийн тамир, спортоор хичээллэх зорилгоор спорт цогцолбор болон "Б" заал, бялдаржуулах төвийг өглөө, 07:30-09:00 цагийн хооронд тогтмол Албан байгууллагууд болон ард иргэдэд үнэ төлбөргүй хичээллэх боломжийг бүрдүүлж. "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөнийг улсын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээнд оролцох албан байгууллагуудын хуваарь гаргаж тогтмол хуваарийн дагуу ажиллав.
Зорилт 2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	Арга хэмжээ 1. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион явуулж, биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ	Улсын төсөв	Биеийн тамираар хичээллэгчдийн тоо	2020 онд 6100	2021 онд 7200 2022 онд 7600 2023 онд 8000 2024 онд 8500 хүргэнэ	Аймгийн аварга шалгаруулах болон Олон улс, бүсийн тэмцээнүүдийг спортын холбоод, аж ахуйн нэгж, албан байгууллагуудтай хамтран зохион явуулж төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулсан. Төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх спорт цогцолбор болон "Б" зааланд спортоор хичээллэх боломжийг бүрдүүлсэн.
	Арга хэмжээ 2. "Мөнгөн өвөл" бүх нийтийн өдөрлөгийн арга хэмжээг спортын 6 төрлөөр жил бүрийн 2-р сард аймгийн хэмжээнд зохион явуулна.	Орон нутгийн төсөв 4,5 сая төгрөг	Хамрагдсан хүний тоо	2020 онд явагдаагүй	2021 онд 1500 2022 онд 2200 2023 онд 3500 2024 онд 4000 хамруулах	"Мөнгөн өвөл" нийтийг хамарсан өдөрлөгийн арга хэмжээг 2024 оны 2-р сард тусгай зааврын дагуу олон нийтийн дунд нээлттэй зохион байгуулж явуулсан. Арга хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, гэр бүлийн хүрээнд Толбо нуурт зохион байгуулагдахад нийт 21 байгууллага, 18 гэр бүл идэвхтэй оролцсон. Албан байгууллага, гэр бүлийн гишүүдийг тус тусад нь байр эзлүүлж, эхний 3 байрыг шалгаруулж үнэ бүхий зүйлээр шагнаан урамшуулав. Арга хэмжээнд нийт 1800 хүн хамрагдсан.
	Арга хэмжээ 3. "Иргэдийн спортын наадам"-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	Улсын төсөв	Зохион байгуулсан тоо	Анх 2018 онд зохион байгуулсан	2022 онд 1 2024 онд 1	"Иргэдийн спортын наадам"-ыг спортын 6 төрлөөр бүсчилж Алтанцөгц, Ногооннуур, Өлгий сумдад 2024 оны 10 дугаар сард төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгууллаа.

Үндсэн чиг үүргийн нэр: Спортын сургалт дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан өсвөр үеийн шигшээ багийн тамирчдын спортын амжилтыг улс, олон улс, тив дэлхийн түвшинд хүргэх						
	Арга хэмжээ 1. Монголын үндэсний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион явуулж буй аливаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдагчдын тоо	Үндэсний спортын төрлийн 3 арга хэмжээнд 1200 хүн хамрагдсан	2021 онд 5 арга хэмжээ, 1800 хүн хамрагдана 2022 онд 6 арга хэмжээ, 2000 хүн хамрагдана 2023 онд 8 арга хэмжээ, 2500 хүн хамрагдана 2024 онд 10 арга хэмжээнд 3200 хүн хамрагдсан байна	2024 онд 6 арга хэмжээ явагдаж нийт 900 хүн хамрагдсан
Зорилт 4. Монгол үндэсний уламжлалт спортыг орон нутагт сурталчлан таниулахад төрийн бодлогыг дэмжиж	Арга хэмжээ 2. Орон нутагт түлхүү хөгжүүлэх спортын төрлүүдээр Олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг жил бүр зохион явуулна	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Олон улс, улсын чанартай уралдаан тэмцээний тоо	2020 улсын чанартай тэмцээн зохион явагдаагүй	2021 онд 2 арга хэмжээ 2022 онд 3 арга хэмжээ 2023 онд 3 арга хэмжээ 2024 онд 6 арга хэмжээ	Монгол Улсад орчин цагийн биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Монголын Тусгай Олимпын Хороотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд улсын чанартай өвлийн наадам 2024 оны 03-р сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн дунд гар дээр сүниалтын анхдугаар нээлттэй тэмцээн, таеквондогийн клубуудын баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн, /Мас-Рестлинг/ модон барилдааны аварга шалгаруулах нээлттэй тэмцээнүүд амжилттай зохион байгуулагдсан. 2024 онд улсын чанартай тэмцээн 1 удаа, бүсийн чанартай тэмцээнийг 3 удаа амжилттай зохион байгуулж явуулсан. Волейболын спортын төрөлд олон улсын хамтарсан бэлтгэл сургалт, нөхөрсөг тэмцээн 1 удаа орон нутагтаа зохион явуулав.

Оодгтотын дэмжлэг, тэмцээн, наадмыг жил бүр зохион байгуулна Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.2 дахь заалтын төлөвлөлтийн уялдаа	Арга хэмжээ 3. Аймгийн аварга шалгаруулах тэмцээн, спортын наадам, арга хэмжээг иргэдийн дунд насны ангиллаар зохион явуулна.	Жил бүрийн батлагдсан төсөв	Спортын арга хэмжээний тоо	2020 онд 25 арга хэмжээ явагдсан	2021 онд 32 арга хэмжээ 2022 онд 46 арга хэмжээ 2023 онд 58 арга хэмжээ 2024 онд 65 арга хэмжээ	2024 онд аймгийн хэмжээнд зохион байгуулагдах биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, арга хэмжээний төлөвлөгөөний дагуу аймгийн биеийн тамир, спортын газрын Спорт цогцолбор болон “Б” зааланд улсын төсөв, ивээн тэтгэлгээр нийтийг хамарсан спортын арга хэмжээг нийт 57 удаа зохион явуулсан. Үүнд: Насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үеийнхний дунд аймгийн аварга шалгаруулах тэмцээн 28 удаа, нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээ 25 удаа, улс, бүсийн чанартай тэмцээн 4 удаа зохион байгуулж явууллаа. 2024 онд зохион байгуулагдсан уралдаан тэмцээний талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд тогтмол сурталчилж ажиллаа.
	Арга хэмжээ 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжлэг үзүүлнэ	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын үйл ажиллагааг хувиар		2021 онд 5 хувь 2022 онд 5 хувь 2023 онд 8 хувь 2024 онд 10 хувьд хүргэх	Тусгай олимпын хөдөлгөөнийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах, оюуны бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, бие бялдрын хөгжил, чадвар, боломжийг нэмэгдүүлэх, тэдэнд урам дэм өгөх, туршлага хуваалцах, гэр бүл хоорондоо танилцаж нөхөрлөх боломжоор хангах, эерэг хандлага тогтоох, нийгэмшүүлэх зорилгоор Монголын Тусгай Олимпын Хороотой хамтран Баруун Бүсийн Өвлийн наадмыг 2024 оны 03-р сарын 28-29-ний өдрүүдэд Баян-Өлгий аймгийн БТСГ-ын Спорт цогцолбор болон Зээгтийн даваанд зохион явуулсан. Уг наадамд баруун бүсийн Увс, Ховд, Говь-Алтай Завхан аймгуудаас гадна Өвөрхангай аймаг, Орхон аймаг, УБ хотын "Сайн найз" клубийн баг тамирчид оролцов. Бочи, Бадминтон, Гүйлтийн цанын гуталтай гүйлт зэрэг спортын төрлүүдээр зохион байгуулагдсан.Мөн “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР” аяны “БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БҮТЭЭЛЧ САР-2024” арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний эцэг эх, асран хамгаалагч нарын дунд зохион явуулсан Бочийгийн тэмцээн 2024 оны 11-р сарын 21-ний өдөр О.Бахытын нэрэмжид спорт цогцолборт амжилттай зохион байгуулагдав. Уг тэмцээнд 40 гаруй хүүхэд эцэг эх асран хамгаалагчид 8 баг болж оролцов.
	Арга хэмжээ 5. Олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдаа оролцуулна	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Медалийн тоо	2020 онд 27 медаль хүртсэн	2021 онд 32 медаль 2022 онд 38 медаль 2023 онд 50 медаль	2024 онд 70 медаль

Зорилт 5. Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын Улс, бүсийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах	Арга хэмжээ 1. Аймгийн Засаг даргын дэргэд өсвөр үеийн шигшээ багийн спортын 8 төрлөөр байгуулна	Орон нутгийн төсөв 92.0 сая төгрөг	Өсвөр үеийн шигшээ багтай болсон байна	Албан ёсны өсвөр үеийн шигшээ баг байхгүй	Засаг даргын захирамжаар албан ёсоор 2022 онд байгуулагдана	Аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/506 тоот захирамжаар өсвөр үеийн шигшээ багийн спортын 10 төрлөөр байгуулагдсан.
	Арга хэмжээ 2. Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад жилд нэг удаа мөнгөн шагнал олгох	Орон нутгийн төсөв Засаг даргын нөөц хөрөнгө	Тив дэлхий, Олон улс, улсын чанартай тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдын тоо	11 тамирчин, дасгалжуулагч нарт 1.425.0 мян төгрөг олгосон	2021 онд 25 тамирчин 2022 онд 35 тамирчин 2023 онд 60 тамирчин 2024 онд 85 тамирчин	Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагч нарыг мөнгөн шагналаар шагнах журамаймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан. 2021, 2022, 2023 онуудад спортын өндөр амжилт гаргасан нийт 131 тамирчин, дасгалжуулагчдад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 39.575 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгогдсон.
	Арга хэмжээ 3. Өсвөр үеийн хүүхдүүдийн дунд секц, дугуйланг тогтмол системтэй хичээллүүлж, спортын төрлүүдийн тоог нэмэгдүүлнэ		Спортын төрлийн тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2020 онд Спортын 8 секц дугуйланд 185 хүүхэд хамрагдсан	2021 онд 10 төрөл, 200 хүүхэд 2022 онд 10 төрөл, 250 хүүхэд 2023 онд 12 төрөл, 300 хүүхэд 2024 онд 13 төрөл, төрөл 350 хүүхэд	Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дугаар 23-ны өдрийн А/969 тоот захирамжаар орон нутагт түлхүү хөгжүүлэх чөлөөт бөх, бокс, жүдо, сагсан бөмбөг, волейбол, хүндийн өргөлт, таеквондо, хөл бөмбөг, шатар, ширээний теннис зэрэг спортын 10 төрлөөр өсвөр үеийн шигшээ баг албан ёсоор байгуулагдан үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Олон улс, улс, бүсийн чанартай уралдан тэмцээнд оролцох тамирчдын замын зардалд Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 13 сая төгрөг шийдвэрлэсэн. Шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургуулилт аймгийн Биеийн тамир, спортын газарт тогтмол явагдаж байна. Шаардлагатай байгаа спортын хэрэглэл материал, тоног төхөөрөмжийн судалгааг холбогдох байгууллагад хүргүүлсэн.
	Арга хэмжээ 4. Биеийн тамирын дасгалжуулагч, арга зүйч багш нарыг чадваржуулах гадаад, дотоодын сургалтад хамруулж ажиллах	Орон нутгийн төсөв	Арга зүйч, багш дасгалжуулагчдын тоо		2021 онд 2 2022 онд 3 2023 онд 2 2024 онд 3-аар нэмэгдүүлэх	2024 онд салбарын дасгалжуулагч, арга зүйч багш нарыг чадваржуулах гадаад, дотоодын сургалтанд давхардсан тоогоор 15 хүнийг хамруулсан.

Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах

Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн байгууллагын нийтлэг чиг үүрэг

Зорилт 6. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, байгууллагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах	Арга хэмжээ 1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хууль, журамд заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлнэ		Тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт үнэлгээгээр	Хэрэгжилтийн үнэлгээгээр	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 70%-иас доошгүй үнэлэгдсэн байна	Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ, биелэлтүүдийг хуулийн хугацаанд харьяа дээд шатны байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байгаа.
	Арга хэмжээ 2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, тайлагнах		Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Стратеги төлөвлөгөөг 2021 онд батлах	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 80-аас доошгүй байна	Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион явуулсан 2024 оны 06-р сарын 11-ний өдөр төв талбайд зохион явуулсан “Хууль сурталчлах” өдөрлөгийн арга хэмжээнд идэвхтэй хамрагдсан. Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж буй бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлж ажилчдын хөдөлмөрийн гэрээг шинэчилэн байгууллаа. Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.
	Арга хэмжээ 3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2021 онд шинэчлэн батлах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 80%-аас доошгүй байна.	Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга УИХ-аар хэлэлцэгдэн батлагдсан. Спортын салбарын ажилтан, албан хаагчдын цалингийн сүлжээ, шатлал шинээр батлагдаж нийгмийн баталгаа хангагдсан. Мөн байгууллагын дотоод журамаар ажилтан албан хаагч нарт ар гэрийн гачигдал, баяр ёслолоос шалтгаалан нэг удаагийн буцалтгүй тусламж олгож байгаа.

Арга хэмжээ 4. Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана		Салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ	Үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн		2024 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны батлагдсан шичэг орон тооны дагуу тус байгууллагад Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний орон тоо шинээр батлагдан салбарынБиеийн тамир, спортын тухай хууль, хуулийн шинэчилсэн найруулга, салбарын хүрээнд мөрдөгдөж байгаа бусад хууль, эрх зүйн актуудыг цаг тухайд нь долоо хоногийн өглөөний хуралд албан хаагч нарт танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
--	--	--	---	--	--

Зорилт 7. Байгууллагын төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах	Арга хэмжээ 1. Байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулна		Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх	2023 оны батлагдсан төсөв	Төсвийн зарцуулалт зөрчилгүй байна.	Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага, зөрчил дутагдалгүй ажилласан. Спорт цогцолборт их засвар хийлгэхээр зураг төсвийг холбогдох байгууллагаар хийлгэж аймгийн ЗДТГ-т хүргүүлэн ажиллав.
Зорилт 8. Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хяналт тавих	Арга хэмжээ 1. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, хяналт тавих		Байгууллагын үйл ажиллагаанд хяналт - шинжилгээ, үнэлгээг жилд 2 удаа хийнэ.	Хийгдсэн	Жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт - шинжилгээ, үнэлгээ 2 удаа хийсэн байна	Байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүүд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийлгэж, хэрэглэл материал, хөрөнгийн тооллогыг хийж орон нутгийн өмчийн бүртгэлд оруулан коджуулж тооллогод хамрагдсан.

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭСЭН:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Баян-Өлгий аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга

Маханбет Еркебулан 2024 оны 12 дугаар сарын 16

Хайсанай Хайнар 2024 оны 12 дугаар сарын 16

Баян-Өлгий аймгийн биеийн тамир, спортын газар

